



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/27-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкэр Тилли Далайван аудит" ХХК Утас:99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 6 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ЛХАГВАЖАВ ТАНАА

᠒᠐᠒᠕. ᠐᠗. ᠒5 № ᠒᠐᠒5/᠒7-НН-СН-᠓᠒

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 18,388.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,283,630.73	130,099,650.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	63,277,481.58	80,574,645.11
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	63,277,481.58	80,574,645.11
31210	Төгрөг	63,277,481.58	80,574,645.11
31211	Төрийн сангийн харилцах	63,277,481.58	80,574,645.11
33	АВЛАГА	0.00	159,188.41
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	159,188.41
35	БАРАА МАТЕРИАЛ	27,006,149.15	49,365,817.15
35400	Хангамжийн материал	27,006,149.15	49,365,817.15
35410	Бичиг хэргийн материал	1,915,500.00	219,200.00
35420	Аж ахуйн материал	13,616,345.50	13,378,863.50
35460	Хүнсний материал	1,614,002.25	1,794,352.25
35470	Бусад хангамжийн материал	9,860,301.40	33,973,401.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,128,242,906.59	1,110,874,257.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,128,242,906.59	1,110,874,257.04
39200	Биет хөрөнгө	1,111,867,906.45	1,094,749,256.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,130,074,193.00	1,130,074,193.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(104,345,313.40)	(120,480,186.04)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	101,039,058.64	118,387,358.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,873,523.50)	(61,635,167.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,969,086.00	61,244,086.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,693,699.49)	(45,635,372.19)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,339,592.00	14,339,592.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,874,186.80)	(3,777,946.88)
39217	Ном	2,232,700.00	2,232,700.00
39300	Биет бус хөрөнгө	16,375,000.14	16,125,000.18
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(874,999.86)	(1,124,999.82)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,000,000.00	16,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,218,526,537.32	1,240,973,907.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	9,591.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	9,591.29
413	Өглөг	0.00	9,591.29
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	9,591.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,218,526,537.32	1,240,964,316.42
51	Засгийн газрын хувь оролцоо	1,218,526,537.32	1,240,964,316.42
51100	Засгийн газрын оруулсан капитал	97,199,969.64	97,199,969.64
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,106,106,414.89	1,128,544,193.99
51210	Өмнөх үеийн үр дүн	1,106,106,414.89	1,106,106,414.89

51220	Тайлант үеийн үр дүн	0.00	22,437,779.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,220,152.79	15,220,152.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,218,526,537.32	1,240,973,907.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	862,933,016.89	1,131,676,411.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	8,088,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	8,088,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	8,088,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	8,088,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	100,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	862,833,016.89	1,123,588,411.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	787,109,300.00	1,041,279,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	787,109,300.00	1,041,279,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,300,000.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,300,000.00	5,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,423,716.89	77,309,111.51
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,423,716.89	0.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	77,309,111.51
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	805,235,386.45	1,109,238,632.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	805,235,386.45	1,109,238,632.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	791,209,086.45	1,097,286,234.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,261,944.83	776,695,842.18
210101	Үндсэн цалин	389,387,960.88	541,144,960.78
210102	Нэмэгдэл	120,603,461.40	204,367,204.32
210104	Урамшуулал	18,270,522.55	31,183,677.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,499,406.79	97,537,127.17
210201	Тэтгэврийн даатгал	48,709,640.56	66,484,202.68
210202	Тэтгэмжийн даатгал	5,730,845.94	7,778,232.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,566,316.78	3,946,519.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,129,782.40	3,856,666.04
210205	Эрүүл мэндийн даатгал	11,362,821.11	15,471,506.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,957,716.89	60,928,411.51
210301	Гэрэл, цахилгаан	8,823,015.77	9,727,117.27
210302	Түлш, халаалт	44,992,651.12	44,740,234.24
210303	Цэвэр, бохир ус	8,142,050.00	6,461,060.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00

210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	79,147,800.00	84,728,020.00
210502	Хоол, хүнс	79,147,800.00	84,728,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,465,600.00	16,380,700.00
210604	Урсгал засвар	3,465,600.00	16,380,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	284,014.00	1,693,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	284,014.00	1,693,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,592,603.94	59,322,333.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,498,566.00	19,142,584.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,491,000.00	5,187,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,603,037.94	34,991,949.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,026,300.00	11,952,398.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,026,300.00	11,952,398.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,026,300.00	11,952,398.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	57,697,630.44	22,437,779.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	57,697,630.44	22,437,779.10

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	862,833,016.89	1,123,588,411.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	862,833,016.89	1,123,588,411.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	787,109,300.00	1,041,279,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	787,109,300.00	1,041,279,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,300,000.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,300,000.00	5,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,423,716.89	77,309,111.51
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,423,716.89	0.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	77,309,111.51
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	783,181,908.51	1,096,755,947.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	783,181,908.51	1,096,755,947.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	769,155,608.51	1,084,803,549.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,261,944.83	776,855,030.59
210101	Үндсэн цалин	389,387,960.88	541,304,149.19
210102	Нэмэгдэл	120,603,461.40	204,367,204.32
210104	Урамшуулал	18,270,522.55	31,183,677.08

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,499,406.79	97,527,535.88
210201	Тэтгэврийн даатгал	48,709,640.56	66,474,611.39
210202	Тэтгэмжийн даатгал	5,730,845.94	7,778,232.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,566,316.78	3,946,516.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,129,782.40	3,856,669.04
210205	Эрүүл мэндийн даатгал	11,362,821.11	15,471,506.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,957,716.89	60,928,411.51
210301	Гэрэл, цахилгаан	8,823,015.77	9,727,117.27
210302	Түлш, халаалт	44,992,651.12	44,740,234.24
210303	Цэвэр, бохир ус	8,142,050.00	6,461,060.00
2105	Нормативт зардал	80,514,860.00	84,908,370.00
210502	Хоол, хүнс	80,514,860.00	84,908,370.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,466,000.00	16,380,700.00
210604	Урсгал засвар	3,466,000.00	16,380,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	284,014.00	1,693,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	284,014.00	1,693,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,171,666.00	46,509,702.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,866,400.00	38,785,902.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,305,266.00	7,723,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,026,300.00	11,952,398.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,026,300.00	11,952,398.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,026,300.00	11,952,398.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	79,651,108.38	26,832,463.53
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,046,500.00	9,535,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,046,500.00	9,535,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,046,500.00	9,535,300.00
222001	Тоног төхөөрөмж	14,550,000.00	9,535,300.00
223001	Бусад хөрөнгө	4,496,500.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(19,046,500.00)	(9,535,300.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	60,604,608.38	17,297,163.53
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		63,277,481.58
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		80,574,645.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,083,827,824.20	1,196,247,946.63
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	22,278,590.69	22,278,590.69
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,106,106,414.89	1,218,526,537.32
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	22,437,779.10	22,437,779.10
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,128,544,193.99	1,240,964,316.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,191,017,300.00	1,106,291,247.98	84,726,052.02	92.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,191,017,300.00	1,096,755,947.98	94,261,352.02	92.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,179,064,900.00	1,084,803,549.98	94,261,350.02	92.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	847,403,300.00	776,855,030.59	70,548,269.41	91.7
210101	Үндсэн цалин	579,038,900.00	541,304,149.19	37,734,750.81	93.5
210102	Нэмэгдэл	250,276,100.00	204,367,204.32	45,908,895.68	81.7
210104	Урамшуулал	18,088,300.00	31,183,677.08	(13,095,377.08)	172.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,960,000.00	97,527,535.88	3,432,464.12	96.6
210201	Тэтгэврийн даатгал	68,654,000.00	66,474,611.39	2,179,388.61	96.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,075,500.00	7,778,232.91	297,267.09	96.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,038,400.00	3,946,516.50	91,883.50	97.7
210204	Ажилгүйдлийн даатгал	4,038,400.00	3,856,669.04	181,730.96	95.5
210205	Эрүүл мэндийн даатгал	16,153,700.00	15,471,506.04	682,193.96	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,220,400.00	60,928,411.51	2,291,988.49	96.4
210301	Гэрэл, цахилгаан	9,805,200.00	9,727,117.27	78,082.73	99.2
210302	Түлш, халаалт	44,739,000.00	44,740,234.24	(1,234.24)	100.0
210303	Цэвэр, бохир ус	8,676,200.00	6,461,060.00	2,215,140.00	74.5
2105	Нормативт зардал	88,571,500.00	84,908,370.00	3,663,130.00	95.9
210502	Хоол, хүнс	88,571,500.00	84,908,370.00	3,663,130.00	95.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,383,000.00	16,380,700.00	2,300.00	100.0
210604	Урсгал засвар	16,383,000.00	16,380,700.00	2,300.00	100.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,789,600.00	1,693,800.00	7,095,800.00	19.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	0.00	5,000,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,789,600.00	1,693,800.00	2,095,800.00	44.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,737,100.00	46,509,702.00	7,227,398.00	86.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,002,800.00	38,785,902.00	7,216,898.00	84.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,734,300.00	7,723,800.00	10,500.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,952,400.00	11,952,398.00	2.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,952,400.00	11,952,398.00	2.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,952,400.00	11,952,398.00	2.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	9,535,300.00	(9,535,300.00)	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	9,535,300.00	(9,535,300.00)	
222001	Тоног төхөөрөмж	0.00	9,535,300.00	(9,535,300.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,181,865,893.09	1,123,588,411.51	58,277,481.58	95.1
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,041,279,300.00	1,046,279,300.00	(5,000,000.00)	100.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,041,279,300.00	1,041,279,300.00	0.00	100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	5,000,000.00	(5,000,000.00)	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	77,309,111.51	77,309,111.51	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	63,277,481.58	63,277,481.58	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		80,574,645.11	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 6 дугаар цэцэрлэг нь “Боловсролын салбарын хөгжлийн бодлогод нийцүүлэн, гэр бүл, хамт олноо дээдэлсэн эрүүл, аз жаргалтай, төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлага дэг журмыг сахисан, багаар ажиллах чадвартай шилдэг арга зүйтэй, мэргэшсэн чадварлаг боловсон хүчинтэй эцэг эх, олон нийтийн итгэл хүндэтгэлийг хүлээсэн хүүхдэд ээлтэй байгууллага болно” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын удирдлагыг боловсронгуй болгох /боловсон хүчний нөөц, биет нөөц, санхүүгийн нөөц/,
- Хүүхэд хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах, хөгжүүлэх үйл ажиллагааны арга зүй, хүүхэд бүрийн хөгжлийн ахицад тулгуурлах,
- Сургалтын таатай орчин бүрдүүлэх /засвар үйлчилгээ, орчны тохижилт/,
- Цэцэрлэгийн үйл ажиллагааны тогтвортой хөгжил, нийгмийн хүрээн дэх түншлэл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт,

шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,447.4 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	63,277.5	80,574.6	17,297.1
Авлага		159.2	159.2

Бараа материал	27,006.1	49,365.8	22,359.7
Үндсэн хөрөнгө	1,128,242.9	1,110,874.3	(17,368.6)
Нийт хөрөнгө	1,218,526.5	1,240,973.9	22,447.4
Өр төлбөр		9.6	9.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,218,526.5	1,240,964.3	22,437.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,218,526.5	1,240,973.9	22,447.4

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 80,574.6 мянган төгрөг болж 17,297.1 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 49,365.8 мянган төгрөг болж 22,359.7 мянган төгрөгөөр өссөн нь 143,452.8 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 121,093.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,343,528.0 мянган төгрөг болж 17,623.3 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-аас 8,088.0 мянган төгрөгийн Chorumbook4, төсвийн хөрөнгөөр 9,535.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, 34,992.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Өглөг дансны үлдэгдэл 9.6 мянган төгрөгөөр өссөн НДШ-ийг илүү шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 789,998.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 72,284.2 мянган төгрөг, нийт 862,282.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 88,536.8 мянган төгрөгөөр бууруулж бараа үйлчилгээний бусад зардлыг 11,698.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсвийг 785,444.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 368,997.6 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 592.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,715.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 25,948.9 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 7,319.2 мянган төгрөгөөр, нийт 405,573.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 1,030,839.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 79,603.4 мянган

төгрөг, урьд оны үлдэгдлээс 80,574.6 мянган төгрөг төсвийг нийт **1,191,017.3** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,191,017.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,106,291.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,106,291.2 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь хүүхдийн хоолны зардлыг 3,663.1 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 81,063.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган					
		төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802- Сургуулийн өмнөх боловсрол	1	80233- хүүхэд хамгаалал	1,167.2	1,010.1	157.1	86.5
		2	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,783.5	1,783.5	-	100.0
		3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	88,571.5	84,908.4	3,663.1	95.9
		4	81816- Зөв монгол хүүхэд	3,035.6	2,990.5	45.1	98.5
		5	81823- Боловсролын багшийн сургалт	1,803.4	1,250.0	553.4	69.3
		6	81834- Боловсролын стандарт сургалт	978,757.2	902,658.2	76,099.0	92.2
		7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	31,295.5	29,381.4	1,914.1	93.9
		8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	79,603.4	77,309.1	2,294.3	97.1
		9	83603-Нэмэлт санхүүжилт	5,000.0	5,000.0	-	100.0
Нийт				1,191,017.3	1,106,291.2	84,726.1	92.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 69,969.3 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч, оролцогч ирээгүйгээс Шанзан ташуур” ХХК, “Уужим хараа” ХХК, “Амьд шим” ХХК, “Ноцох дөл” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундаръяа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 805,235.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,052.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын 6 дугаар цэцэрлэг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 170 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан-1

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгө, цалин хөлстэй холбоотой 2 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5,235.6	2	5,235.6	100.0
Нийт дүн	2	5,236.5	2	1,752.8	100.0

/мянган
төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

Аудитаар нийт **14,556.7** мянган төгрөгийн зөрчил илэрч 936.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,564.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 10,055.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

1. Тооцооллын алдаанаас шалтгаалж, 4 багшид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2-3 хувиар илүү тооцож **936.7** мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсанд хийсэн ажил, ажилласан хугацаа зэрэг үзүүлэлтүүдийг тодорхой бичээгүй буюу анхан шатны бүрдэл дутуу баримтаар нягтлан бодогч Ариунжаргалд 2 удаа тус 5 цагаар тооцон нийт **315.3** мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгож, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын

бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсанд хийсэн ажил, ажилласан хугацаа зэрэг үзүүлэлтүүдийг тодорхой бичих буюу анхан шатны баримтын бүрдлийг хангасны үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

2. Тус цэцэрлэгийн арга зүйч, бусад багш, туслах багш нарын ур чадварын үнэлгээ, нэмэгдэл цалинтай холбоотой дараах зөрчил илэрсэн нь БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 6-д “*Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно*”, 7-д “*Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно*” гэсэн заалт болон 10 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Арга зүйч Л.Эрдэнэзаяагийн ур чадварыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хагас жил тутам үнэлж, дүгнээгүй, цэцэрлэг, сум, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр сар бүр 20 хувиар тооцон нийт **3,249.4** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон,
- Багш, туслах багшийн ур чадварыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хагас жил тутам огт үнэлдэггүй, гаргасан амжилтыг харгалзан батлагдсан төсөвт багтаан сар бүр ур чадварын нэмэгдэл /10-25 хувь/ олгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Арга зүйч, багш, туслах багш нарын ур чадварыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хагас бүтэн жилээр дүгнэж, цэцэрлэг, сум, аймаг, улсын түвшинд гаргасан амжилтыг үндэслэн батлагдсан төсөвт багтаан сар бүр ур чадварын нэмэгдэл олгож байх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Зайлшгүй шаардлагын улмаас цэцэрлэгийн орон тоонд батлагдаагүй бичиг хэргийн ажлыг хавсарсан гэх үндэслэлээр нярав П.Долгормаад нэмэгдэл цалин хөлс олгохоор шийдвэрлэж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

2. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 **Илрүүлэлт:** Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 10,055.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4 дэх Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 –ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	936.7	1	936.7								
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйцэтгэж гүйцэтгэсэн	1	315.3			1	315.3						
Ур чадварыг журмын дагуу үнэлж, нэмэгдэл хөлс олгоогүй	1	3249.4			1	3.249.4						
Батлагдаагүй орон тоог хавсран гүйцэтгүүлсэн	1	-					1					

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

